



Улсын үндсэн хуулинд оорчлолт оруулах эсэх тухай яриа хоороо чих дэлсэх болсоор А нэлээд хугацаа онгоров. “Үндсэн хуулинд гар хүрч болно”, “болохгвй”, “дордуулсан долоон оорчлолтоос болж үндсэн хуулийн бэх бат чанарт цав суусан”, “уг хуулин дахь эрх мэдлийн хувиарлалт, торийн байгуулалтын зарчимыг эргэж харах зайлшгвй шаардлага байна” гэх мэтээр УИХ-ын танхимд суугаа эрхэмүүдээс эхлээд сумын товийн гудманд алхаж яваа иргэдийн хооронд ч ve ve энэхүү чухал ярианы сэдэв сохогдсоор байх...

Эрх барьж байгаа улс торийн хүчин УИХ болон орон нутгийн сонгуулийн омо үндсэн хуулийг оорчлох асуудлыг ард түмэнтэйгээ зовлоно гэж ам шүд алдсан учир, үүнийхээ дагуу арга хэмжээ авч эхлээд байгаа нь УИХ дээр энэ асуудал ve, ve яригдаж, улмаар бүх ард түмний санал асуулга явуулах, явуулахгвй байх талаар мэтгэлцээн үүсч байгаа зэргээс харагдаж байна. Зарим хүмүүсийн хувьд оноодор бий болсон улс торийн гажуудал, эдийн засаг, нийгмийн хямрал доройтолд нолоолж буй суурь хүчин зүйлүүдийг үндсэн хуультай холбон тайлбарлах нь ч бас байна. Эдгээрийг бүхэлд нь ажиглаж байхад нэгэн том дүр зураг сүүдийн үзэгдэж буй нь юу гэвэл оноодор манай улсад оршин буй торийн байгуулалтын тогтолцоо ард нийтийн толооллийг бүрэн хангаж чадахгвй, тэдний оролцоо хүсэл зоригоос гадуур оршиж байгаа байдал юм.

Иймэрхүү үзэл бодлыг олон хүний бичсэн зүйлээс, ярьсан ярианаас сонссоноос гадна. хоёр жилийн омо манай аймгийн нэгэн чамбай сэхээтэн нийгмийн гажуудлыг хэрхэн зов гольдрол руу чиглүүлэх тухай арга замын талаар цогц хотолборийн санааг гаргасан байсан нь мон л ийм агуулгатай байсан. Тэр эрхэмийн тосооллоор бол торийн байгуулалтыг суурь бүтцээр нь оорчлох ёстой богоод Монгол улс нь Улсын их хурал, бага хурал гэсэн торийн эрх барих “парламент”-ийн хоёр танхимтай байх, чингэхдээ Улсын Их Хурлыг нам харгалзахгвйгээр Засаг захиргааны нэгж бүрээс толоолол сонгох зарчимаар бүрдүүлэх, ингэснээр Монгол улсын сум болгоноос тухайн сумандаа байнгын оршин сууж буй нэгээс доошгвй иргэн УИХ-д толоологч, эсвэл гишүүнээр суух ба уг Их хурал нь Монгол улсын торийн эрх барих хамгийн дээд байгууллага байх. Улсын Бага Хурлын тухайд хууль тогтоох мэргэжлийн танхим богоод мон л нам харгалзахгвйгээр улсыг бүхэлд нь нэг тойрог болгон тэндээс гишүүдийг нь сонгож бүрдүүлэх, улс торийн намуудыг торийн бүтцийг бий болгодог “нооц сав”-ны зохион байгуулалтаас нь болиулж, зовхон улс торийн онол, судалгааг эрхэлсэн институцын түвшинд аваачих, ингэж байж одоогийн үндсэн хуулинд байгаа Торийн эрх мэдэл ард түмний гарт байна гэсэн тунхагийг хангах боломжтойг сайтар тайлбарласан байсан ба уг үзэл баримтлалын /конц епц / тослоо Монгол улсын Ерөнхийлогч, Улсын их хурлын дарга, Ерөнхий сайдад ч явуулсан

гэдэг.

Тэднээс ганц нэгхэн нь таны захидлыг үзлээ, танилцлаа гэх тодий хариу ирүүлсэн бол ихэнхийнх нь хувьд “усанд хаясан чулуу” шиг ямар ч хариу оголгвйгээр таг чиг сураг алдарсан гэх. Тухайн үедээ бас хэсэг нохдийн хврээнд цуглаж, моноох эрхэмийнхээ онол, үзлийг сонсож хэлэлцэн, бараг бvгд л санал нэгтэй дэмжиж байсныг санаж байна. Ү Гэвч дээдсүүдэд хвргэж ажил болгохын тухайд бол “дээшээ тэнгэр хол, доошоо газар хатуу” гэгчийн үлгэр болоод л замхарна гэдэг нь ойлгомжтой байсан хэрэг. Гэтэл тэрхүү санаа звгээр нэг элдэв юм эрэгцүүлж сэдэх дуртай нохрийн сонирхлын асуудал тодий биш “цайзад хашигдсан” ард түмний дундаас хэн нэг нь тэндээсээ гарч болох хамгийн оновчтой гарцыг олж хараад, зурж тэмдэглэсэн анхны гярхай тэмдэглэл байжээ гэхүйц оодрог Ү сэтгэгдэлд эзлэгдэх нэгэн шалтаг бий болов.

Монгол улсын гурав дахь Ерөнхийлогч Н.Энхбаяр тэргүүтэй МАХН-ын ноход Үндсэн хуулийг оорчлон шинэчлэх тосол боловсруулсан тухай мэдээг сонссоор байсан авч энэ хаврын дорвон сар гарч байж л уг тослийг нүдээр уншиж танилцах завшаан тохиосон юм. Уншаад үзэхэд нэлээн олон зүйл дээр оноох “чамбай сэхээтэн”-ий тосоолж байсантай яв, цав нийцжээ. Үндсэн хуулийн энэ тосолд /4.2./ “БНМУ-д тор Засаг, түвний бүрэн эрхийн цорын ганц эх сурвалж нь Монголын ард түмэн мон богоод тор Засгийн бүрэн эрх гагцхүү ард түмний мэдэлд байнга байна. Монголын ард түмэн тор засгийн бүрэн эрхийг энэхүү Үндсэн хууль, түвний утга агуулга, зарчмын дагуу барина” хэмээсэн нь одоо мордогдож буй үндсэн хуулийн

/

3.1.

/

-д буй “Монгол улсад Засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн торийн үйл хэрэгт шууд оролцож, мон сонгож байгуулсан толоологчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдлэнэ” гэснийг илүү дэлгэрүүлэн тодорхой болгосноос гадна, хууль тогтоох эрх мэдлийг хэрхэн бий болгох талаар авч үзсэн хоёр дугаар бүлэг дэх заалтуудаараа үүнийг жинхэнэ утгаар нь баталгаажуулжээ. Тодруулбал хоёрдугаар бүлгийн 26.1-д Монгол улсын хууль тогтоох эрх мэдлийг хадгалан хэрэгжүүлэгч нь парламент байна. Парламент нь хууль тогтоох эрх бүхий Улсын Бага хуралдай, хууль батлах эрх бүхий Үндэсний Их Хуралдайгаас бүрдэнэ.

/

27.5.

/

Үндэсний Их Хуралдайд хороо, тосгон, сум бүрээс нэг толоологч сонгогдоно. Үндэсний Их Хуралдайн толоологчийг сонгуулийн насны иргэд нийтээрээ, чолоотэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж сонгоно.

/

27.12.

/

А А А А А А А А А А А А А А Энэ дагууд авч үзвэл хуулийн тослийн /5.6./-д “Тор, засгийн бүрэн эрхийг хэрэгжүүлэгчид нь вйл ажиллагаагаа харилцан тэнцвэртэй байх зарчмаар явуулах бөгөөд аль нэг нь бусдаасаа давамгайл эрх эдэлж үл болно” хэмээнээрээ эрх мэдэл хувиарлалтын тэнцвэртэй, ардчилсан зарчмыг баримтлах суурь боломжийг бүрдүүлж байна гэж харав.

Мон хуулийн тосолд тор, А засгийн бүтцийг бүрдүүлж буй, дээр авч үзсэн хууль тогтоох засаглалын байгууллагаас гадна бүх шатны шүүхийн шүүгчид, хүний эрхийн үндэсний хороо, хянах эрх мэдлийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий ардын хянан шалгах хорооны албан тушаалтнуудыг мон адил бүх нийтээр, чолоотэй, нууцаар саналаа огох зарчмын дагуу сонгож гаргаж ирэхээр тусгасан нь оноодрийн амьдрал дээрх бараг хавтгай үзэгдэл болж байгаа, эрх мэдлийг наймаалцдаг, нэг эрх мэдлээр ногоо эрх мэдэлтнийг дархлан хамгаалах хэрэгсэл болгодог, эрх мэдэлтний шийдвэр, зан байдлын үйлчлэл нь жирийн олон хийгээд доодост сүх, лантуу мэт, дээдэст бол муур, нохой мэт байдгийг засамжлах гэсэн зов зүйтэй чармайлт биз ээ гэж зовшоох бодол торно. А А

Хуулийн тослийн 4.6. “БНМУ-ын тор засаг Үндсэн хуулиар заасан үүргээ хангалттай биелүүлэхгүй байгаа, эсхүл Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийг зорчсон тохиолдолд ард түмэн эсэргүүцэл илэрхийлж, хугацаанаас нь олно огцруулан, шинээр эмхлэн байгуулах эрхтэй” гэсэн нь ард олны дунд байнга яригдсаар ирсэн авч, эрх мэдэлтэй хэсгийн дийлэнх огт хүлээн зовшоорох бодолгүй байдаг хурц асуудлыг шударга, зоригтой гаргаж тавьснаараа, улс орны хувь заяатай холбоотой бас нэг шударгуу алхам болж байна гэж анзаарсныг маань уншигчид хэрэг болгож эрэгцүүлнэ байхаа гэж найдав. Үүнтэй холбоотой оорийн санааг бататгах гэсэн жишээ энэ, тэр татах нь илүүц зүйл гэж үзээд оор нэг заалтад анхаарлаа хандуулбал /13.32./ “Хүн оорийн болон нийтийн ашиг сонирхол, бусдыг толоолон тэдний ашиг сонирхлын дагуу аливаа байгууллагын шийдвэрлэж байгаа асуудалтай холбогдуулж, хүсэлт, оргодол гомдол гаргах, шийдвэрлүүлэх эрхтэй” гэсэн нь ер анзаарагддаггүй зүйлийг олж харсан, нүдээ олсон заалт болжээ. Дашрамдуулаад нэгэн сонин дэлгэвэл нийтийн ашиг сонирхол, жам ёсыг сахин хамгаалж, түүнтэй холбоотой хууль бус асуудлыг таслан зогсоох үүрэг бүхий байгууллага, албан тушаалтан оороо тэр чиг үүргийнхээ эсрэг ажиллаж, нийтийн эрх ашгийг хохироох, завших вйл үйлдсэн байхад, түүнийг нь мэдээд асуудал тавьж, хуулийн байгууллагад хандсан иргэдийг албан тушаалтнууд, торийн албан хаагчид, тэр ч атугай тангараг оргосон шүүгч нь оороо “нүдээ бүлтийлгэн” гайхаж, энэ асуудал та нарт ямар хамаатай юм бэ хэмээгээд, чухам хамаатай болохыг нь хуульчилж огсон заалтууд холбогдох хуулинд байсаар атал “оорт нь хамаагүй зүйл рүү хошуу дүрж, цор цор гэж буй энэ нохдийн хандыг нь дарж огох хэрэгтэй” гэсэн агуулга бүхий “оровдолтэй” шийдвэр гаргаж байсантай биеэрээ таарч билээ.

Үндсэн хуулийг өөрчилвөөс...

Бичсэн turuu

2017 оны 4-р сарын 17, Даваа гариг, 15:34

Энэ мэтчилэнгээр бодит нохцол байдлыг гярхай ажиглаж, шударгуу зов зохицуулалт хийхийг чармайсан, урьдны бусармаг зүйлсийг нохцолдүүлж байсан хвчин зүйлсийн вйлчлэлийг үгвй болгож, “ээрэг цэнэг үүсгэсэн” заалтууд зонхилсон гэж хэлж болохоор Үндсэн хуулийн оорчлолтийн энэхүү шинэ тослийг хэрэг болгон уншиж, санаа бодлоо нууж хаалгвй илэрхийлэн, эвлэлдэн зовлолдвол улс хийгээд ард бидний ирээдвй, оно хожимд үлэмж тустай болуужин хэмээн үзээд, бултаар анхаарахыг зориудА уриалмаар санагдсан юм.

Басхүү Засаж янзалмаар, бодож тунгамаар зүйл ч нэг бус байгаа болов уу гэснээс энд ганц нэгийг дурьдвал /7.3./ БНМУ-д тор засгийн байгууллагууд албан хэргээ Монгол хэлээр явуулахаас гадна дэлхийн хамгийн түгээмэл хэл болох англи хэлээр явуулж болно гэжээ.А А А

А А А А А А А А А А А А А А Хэл бол үндэсний соёлын эх ундрага, үндэстнийг бүрдүүлж буй язгуур хвчин зүйлсийн нэг гэдгийг бүгд нэвтэрхий ойлгодог агаад торийн хэргийг үндэсний хэлээс бусад хэлээр хотлох, явуулах нь үндэстэн оорийгоо дорд үзсэн хэрэг болохоос гадна оорийн хэл, соёлыг уусган мохоох эх үүтгэл болно гэх санааг эрдэмтэн мэргэд сануулсаар байдаг. “Хэл, хил, мал гурав”-ын тухай нэрт яруу найрагч Зундуйн Дорж гуайн алдарт шүлгээс гадна эртний Монголын Хитан гүрнийг үндэслэгч Елюй Абаужи хааны “Би Нангиад хэлээр ярьж чадамой. Гэвч миний Хитан ард түмэн байгаа цагт би хэзээ ч тэр хэлээр ярихгүй. Хитаны ард түмэн нангиадуудыг дуурайж, аажим аажмаар энэ нь нэмэгдэх болуузай гэхээс би айна”А хэмээсэн зарлигаас огсүүлээд энэ тухай түүхэн сануулга ч олон бийг бодолцох ёстой болов уу !

Мон /11.3/ “БНМУ-ын тор засаг улс торийн олон нам бүхий тогтолцоог дэмжин хамгаалах үүрэгтэй богоод улс торийн намыг санхүүжүүлж болно” гэсэн байхад иргэний нийгэм, торийн бус байгууллагын тухайд /11.4./ ”иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоо, сайн дурын байгууллага, сан зэрэг торийн бус байгууллага байгуулах эрх чолоог хангана” А гэх тодийгоор хязгаарлажээ. Үнэхээр л тор засгийн бүх эрх нь ард түмний мэдэлд байдаг иргэний тор бүхий улс байх аваас иргэдийнхээ үүсгэл санаачлагаар, улс, нийгэмд вйлчилэх зорилготойгоор байгуулж буй байгууллага, эвслийг улс торийн намаас ялгаварлан дорд үзэхгүйгээр, хамгаалах бол адилхан хамгаалж, санхүүжүүлэх бол адилхан санхүүжүүлэх, эс богоос адилхан санхүүжих эрхгүй байхаар зохицуулалт хийх нь зов гэж үзнэ. Тэгээд ч улсыг бүрдүүлж буй А эс ширхэг нь улс торийн нам бус, оюун ухаант бодгаль буюу ард түмэн гэдгийг бодолцох хэрэгтэй бизээ. Түүнчлэн хууль санаачлах эрх зовхон Улсын Бага Хуралдай болон Их Хуралдайн гишүүдэд олгогдоно гэсэн нь учир дутагдалтай санагдав. Энэ тухайд ганцхан жишээг авч үзэхэд одоогийн үндсэн хуулиар уг эрх нь зовхон Ерөнхийлогч, Улсын Их Хурлын

